

## “МАРКО ПОЛОГИЙН АЯЛАЛ” БҮТЭЭЛИЙН ХУВИЛБАНУУДЫН ТУХАЙД

Г. Бат-Учрал<sup>58</sup>  
Элизабетта Рагагнин<sup>59</sup>  
Самуэла Симмон<sup>60</sup>

**Abstract:** *Marco Polo was one of the first Europeans to travel to the Orient. His travelogue, copied several times and translated in various languages, spread all over Europe at that time. Thus, there is a wide range of versions of Marco Polo's travelogue which, however, differ in content as well as in quantity and quality of information. The Venetian humanist Ramusio collated several versions available to him in Venice in the middle of the sixteenth century, and produced the very first critical edition of Marco Polo's travelogue. In this article we underline the importance of his work and discuss some of its peculiarities.*

**Түлхүүр үг:** *Аялын тэмдэглэл, Марко Поло, гар бичмэлийн олон хувилбар*

Дорно дахин руу аялж тэндхийн ард түмний соёл уламжлал, зан заншлын талаарх олон мэдээ мэдээллийг Европ даяар түгээн тархаасан Пиан дэл Карпине хотын Жованни (1243-1247), Андре де Лонжумо (1245-1247), Ашелино ди Ломбардиа /Никола Ашелино/ (1247-?), Гийом де Рубрук (1253-1255) зэрэг олон аялагчид байснаас Пиан дэл Карпине хотын Жованни, Гийом де Рубрук нарын тэмдэглэл хэвлэгдэн олны хүртээл болсон билээ. “Марко Пологийн аялал” ном нь тухайн цаг үедээ дээрх бусад аялагчдын тэмдэглэлээс илүү олны хүртээл болсон нь худалдаачны өнцгөөс харсан буюу зарж худалдаалбал үнэд хүрэх алт эрдэнэс, бараа таваар зэрэг сонин содон олон зүйлийн тухай мэдээг багтааснаараа онцлогтой юм.

### 1. “Марко Пологийн аялал” бүтээлийн тухай

Марко Пологийн ном “*Devisement du Monde*” буюу “Ертөнцийн дүрслэл”, “*Le livre des Merveilles*” буюу “Гайхамшгийн ном”, “*Milione*” буюу “Нэг сая” гэх мэтчилэн өөр өөр гарчигтайгаар олонд танигдсан байна. “*Milione*” гэдэг нь Пологийнхны хоч нэр бөгөөд аялынхаа турш үзэж харсан сонин хачин, элдэв зүйлсийн тоо хэмжээг хэлж байх талтай. Түүний номыг сонирхон уншигчдын тоо нэмэгдсэн тул маш олон тоогоор хуулбарлан бичиж худалдаалж эхэлсэн бөгөөд тухайн үедээ хамгийн эрэлттэй ном болжээ.

<sup>58</sup> МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Европ судлалын тэнхим

<sup>59</sup> Доктор /Ph.D/, Итали, Венецийн Ка Фоскари их сургуулийн Ази ба хойд Африкийн судлалын тэнхим

<sup>60</sup> Доктор /Ph.D/, Итали, Венецийн Ка Фоскари их сургуулийн Хүмүүнлэгийн ухааны тэнхим

“Марко Пологийн аялал” ном нь тухайн цаг үе хүртэл дорно дахины талаарх европчуудын олж мэдэж чадаагүй олон мэдээ мэдээллийг багтааснаас гадна янз бүрийн хүсэл сонирхолтой уншигчдад өөрсдийн өнцгөөс харах боломж олгосноороо өмнөх аялагчдын тэмдэглэл, бүтээлээс илүү их амжилтад хүрч чадсан байна. Уг номыг тухайн үед дараах зорилгоор түлхүү сонирхон уншдаг байв. Үүнд:

1. Гайхамшгийн чуулган
2. Худалдаа наймааны заавар зөвлөмж
3. Монголын эзэнт гүрэн, Хубилай хааны нигүүлсэнгүй зан чанар
4. Газарзүйн ном

Мөн түүнчлэн “Марко Пологийн аялал”-д дурдсан газарзүйн холбогдолтой шинэ мэдээллүүдийг 1375 оны Каталан Атлас (*Catalan Atlas*) болон Фра Маурогийн 1459 оны “Дэлхийн газрын зураг” (*Mapa Mundi*)-ийг хийхэд ашигласан байна. Алдарт аялагч Кристофор Колумб “Марко Пологийн аялал” номд хөтлөгдөж түүнд тэмдэглэгдсэн нутаг оронд хүрэхээр Хятад улсын зүг баруун талаар аялж байгаад Америк тивийг нээсэн бөгөөд түүний гар тэмдэглэлтэй Марко Пологийн номын хувилбар Испанийн Сэвил хотын номын санд хадгалагдаж байна.

“Марко Пологийн аялал” ном тухайн үед Европ даяар түгэн тархаж, олон дахин хуулбарлан бичиж, тэр хирээрээ утга агуулгын хувьд өөрчлөгдсөөр маш олон хувилбар бий болсон хэдий ч эх гар бичмэл нь олдоогүй байна. Марко Пологийн аяллын бичмэлийн энэ олон хувилбарыг эх сурвалж, цаг хугацаа, хэлээр нь багцлан ангилсныг хүснэгт 1.-ээс үзнэ үү.

Хүснэгт 1. “Марко Пологийн аялал” бичмэлийн гол ангилал<sup>61</sup>

Ангиллын тэмдэглэгээ	Цаг хугацаа	Бичигдсэн хэл	Хувилбарын тоо	Тайлбар
F	XIV зуун	франц, итали хосолсон	2	<ul style="list-style-type: none"> <li>• Францын үндэсний номын сан “fr. 1116”</li> <li>• Хувийн цуглуулгаас олдсон бичмэлийн “f” хэсэг</li> </ul>
Fr	XIV зуун	франц	18	<ul style="list-style-type: none"> <li>• Хамгийн эртнийх нь XIV зууны эхээр</li> </ul>
K	XIV зуун	каталан, франц, арагон хэл	3	<ul style="list-style-type: none"> <li>• Хамгийн эртнийх нь XIV-р каталан хэлээр</li> </ul>
L	XIV зуун	латин	6	<ul style="list-style-type: none"> <li>• Хураангуй бичмэл</li> </ul>
LA	XV зуун	латин	9	<ul style="list-style-type: none"> <li>• Латин хэл рүү орчуулсан “TB” бичмэл</li> </ul>
LB	XIV	латин	1	<ul style="list-style-type: none"> <li>• Латин хэл рүү орчуулсан “VA”</li> </ul>

<sup>61</sup> Дэлгэрэнгүйг хар. Gadrat-Ouerfelli (2015: 382-385); Simion (2019: 54-55)

	зуун		1 (гар бичмэлийн хэсэг)	бичмэл
LT	XIV зуун	латин	1	• ТА болон Р эхийн холимог бичмэл (Парисын номын сан, “lat. 3195”)
P	XIV зуун	латин	60 гаруй	• Франческо Пипиногийн латин хэл рүү орчуулсан “VA” бичмэл
TA	XIV зуун	тоскан аялгуу	5	• Хамгийн эртнийх нь XIV зууны эхээр
TB	XIV зуун	тоскан аялгуу	7	• XIV зууны сүүлч үе
V	XIV зуун	венец аялгуу	1	• Берлин хот дахь улсын номын сан, “Hamilton 424”
VA	XIV зуун	хойд итали аялгуу (veneto-emiliana)	5	• Хамгийн эртнийх нь XIV зууны эхээр
VB	XV зуун	венец аялгуу	2	• Венецийн “Чивико Корпер” музей, (Donà delle Rose 224) • Лондоны “Британи номын сан”, (Sloane 251) • Жованни Баттистагийн хүү Рамузио Паологын хувийн цуглуулгын XVI зууны бичмэлийн хэсэг, Ватикан, Ватиканы номлогчдын номын сан, (Barberiniano lat. 5361)
Z	XV зуун	латин	1	• Испанийн Толедогийн “Соёлын өвийн архив болон номын сан” “Zelada ms. 49.20”

“Марко Пологийн аялал” бүтээл нь Венецийн Бүгд Найрамдах улсын төрийн удирдлагын гишүүн Ж.Б.Рамузио (1485-1557)-гийн зохиосон хувилбар юм. Тэрээр 50 гаруй аялагчдын аяллын тэмдэглэлийн анхны гар бичмэлүүдийг цуглуулж чадсан. Ж.Б.Рамузио нь Марко Пологийн аяллын тэмдэглэлийн хамгийн анхны “шүүн тунгаасан” хувилбарыг бичсэн бөгөөд доор дурдсан олон бичмэлийн ангиллыг ашигласан байна. Үүнд:

- латин хэлээрх Z (энэ ангилалд хоёр хувилбар байсан бөгөөд ‘Ghisi codex’ гэх хувилбарыг венец гаралтай нэгэн гэр бүл хувийн цуглуулгаасаа өгсөн),
- венец аялгуугаар бичсэн VB (Рамузиогийн хувийн гар бичмэл),
- венец аялгуугаар бичсэн хураангуй бичмэл V (Hamilton 424),

- латин хэлээрх хураангуй бичмэл (L),
- тухайн үед хамгийн их түгсэн, мөн үеийн Европын эрдэмтдийн хамгийн их судалсан (P)

Рамузиогийн ашигласан ‘Ghisi codex’ хувилбар нь маш чухал бичмэл юм. Марко Поло судлаачдын үздэгээр энэ хувилбар нь гар бичмэлүүдийн “В” ангилалд багтах ба угсаатан зүйн талаас хамгийн олон мэдээлэл агуулдаг. “Марко Пологийн аялал” нь 70 гаруй бичмэлийг нэгтгэн дүгнэж гаргасан хувилбарын орчуулга юм. Марко Пологийн аяллын тэмдэглэлийг Б.Дорж, С.Идшинноров, А.Очир нар “Орчлонгийн элдэв сонин” нэртэйгээр 1987 онд орос хэлээс монгол хэлнээ орчуулсан билээ. “Орчлонгийн элдэв сонин” бүтээлийн орос хэлээрх эх нь “F” ангиллын буюу нэг хувилбарын орчуулга юм. Харин “Марко Пологийн аялал” нь өөр хоорондоо агуулгын зөрөөтэй бусад олон хувилбарт гарсан мэдээллийг нэгтгэж чадсан тул одоогоор хамгийн их мэдээ мэдээлэл агуулсан буюу сонгомол эх хэмээн үзэж болохоор байна.

XVI зууны эртний итали хэлээрх R хувилбар нь дээрх олон бичмэлүүдийн анхны хэвлэмэл хувилбар юм. Рамузиогийн уг бүтээл нас барснаас нь хойш хоёр жилийн дараа буюу 1559 онд Венецийн Жунти хэвлэлийн газраас гаргасан “*Аян Замын Хөтөч ба Аялал*” (Navigazioni e Viaggi) хэмээх бүтээлийнх нь 2-р ботид “Венецийн Марко Поло гуайн аялал” (Dei Viaggi di messer Marco Polo gentiluomo veneziano) хэмээх нэртэйгээр хэвлэгджээ.

## 2. Марко Пологийн тэмдэглэл дэх зарим үг хэллэг, ойлголтын тухайд

Марко Поло худалдаачны гэр бүлд төрж өссөн тул аяллын туршид үзэж харсан олон гайхамшигтай зүйлсээс зарж худалдвал өндөр үнэд хүрэх, ашиг хонжоо олж болохыг нь л голчлон тэмдэглэсэн байна. Түүний аяллын тэмдэглэл гурван хэсгээс бүрдэх нэг ном хэдий ч тэрээр хэсэг тус бүрийг ном гэж тэмдэглэсэн байна. Цаашид дэлгэрүүлэн судлууштай, анхаарал татсан зарим хэсгийг дурдахаас өмнө эдгээр нь зөвхөн “R” хувилбарт гарсан болохыг тэмдэглэх нь зүйтэй.

Нэгдүгээр номын 2-р хэсэгт гарсан “**Caramani**” гэх үг нь зөвхөн “R” болон “Z” хувилбарт дурдагджээ. Карамани буюу Кахараман нь XIII зууны дунд үеэс XV зууны сүүл үе хүртэл Туркийн Анатолын хойгт ноёрхож байсан улс юм.

... хойд талаараа *Карамани (Caramani)* хэмээх түрэгүүд ...

Нэгдүгээр номын 10-р хэсэг дэх “**Barsamo**” буюу “мацагтан хүү” гэсэн утгатай үгийг зөвхөн “R” хувилбарт дурджээ. Энэ нь Сирийн үнэн алдартны Якопит гэгээний нэр юм. Энд дурдсан хийд нь одоогийн Турк улсын Малатиа хотын ойролцоо орших бөгөөд VIII-XIII зуунд якопитуудын хувьд чухал газар байжээ.

... мөргөлийн үеэр *Барсамогийн* тахилын ширээн дээр ...

Нэгдүгээр номын 55-р хэсгийн 10-р зүйлд “**boriat**” гэх үг дурдагдсан нь өөр аль ч бичмэлээс олдоогүй бөгөөд “**ойрадууд**” гэж орчуулжээ. Иймд энэ үгийг цаашид анхааран судлууштай.

“... эрэмгий зоригт *ойрадуудад (боруам/boriat)* л энэхүү ...”

Хоёрдугаар номын 8-р хэсэгт дурдагдах “**Achmach**” нь Хубилай хааны хүү санг хамаарагч алдарт сайд Ахмад Фанакатиг (?-1282) юм. Зөвхөн “R” хувилбарт Ахмад Фанакатиг албан тушаалаа урвуулан ашигласны улмаас алуулсан хэмээн дурджээ.

... жигшүүрт *Акмак* болон хүүхдүүд нь ...

Хоёрдугаар номын 8-р хэсэгт дурдагдах “**Vanchu**” гэх үг нь зөвхөн “R” хувилбарт тэмдэглэгдэн үлджээ. Ванкү (Wanhu 万户) гэдэг үг хятад хэлний ваньху буюу 10000 цэргийн жанжин гэсэн утгатай үг юм.

... ордонд нэвтэрч, *Ванкү* нэгэн сандал ...

Хоёрдугаар номын 26-р хэсгийн 6-р зүйлд “**Achbaluch**” гэх үг дурдагдсан нь “Цагаан хот” гэсэн утгатай түрэг үг бөгөөд Хятад улсын Хэбэй мужид оршдог Жөндин (Zhengding 正定, эртний Zhendingfu) хэмээх хотыг хэлсэн байж магадгүй (Нaw 2006: 95).

“... тав дахь өдрийн орой *Акбалук (Achbaluch)* хэмээх хотод ...”

Монгол хаад ноёд, монголчуудын ахуй амьдралтай холбоотой ойлголт, үг хэллэг гарснаас заримыг нь онцлон дурдъя.

Марко Поло тэмдэглэлдээ Хубилай хааныг “*Gran Can, Gran Tartaro, Gran Chani, Gran Cani, Gran Cane*” гэх мэтчилэн олон хувилбараар бичсэн бөгөөд бусад хувилбаруудад “*Can, Gran(t) Can, Gran(t) Ka(a)n, Grant Kant, Gran(t) Sire(s) / Seingnor(s), Grant Tartar, Ka(a)n, sire grant, Tartar F; Grandis Canis, Kanis, Magnus Canis / Kanis L; Kaam, Magnus Kaam P; Gran Chan(i), Gran Signor(e), Signor(e) / Signori, Signor de tuti i Tartari, Signor deli Tartari, Signori de Tartari, Sumo Signor V; Cha(a)n, Gran Cha(a)n, Gran Segnior(e), Gran Segnior de' Tartari, Grande Cha(a)n, Grande Chaan VA; Gran Can(e), Gran Chan(e), Gran Chan Segnor di Tartari, Gran Segnor Chan, Gran Segnor de' / di Tartari, Segnor(e), Segnor Gran Chan(e) VB; Dominus, Dominus Grandis, Magnus Can, Magnus Dominus Z*” зэргээр тэмдэглэсэн байна. Харин Рамузиогийн нэгдүгээр номын 44-р хэсгээс бусад газар Чингис хааны тухай дурдаагүй байна. Дээрх үг нь уг бүтээлийн бараг хамгийн их давтагдсан үг юм.

Уг бүтээлд “Мөнх хаан”-ыг “*Mongú Can, Manghú Gran Can, Monghú Can, Mangi Can*” гэж 4 янзаар бичсэн бөгөөд бусад хувилбарт “*Mo(n)gu, Mongu Can, Mongu Cha(a)n, Mongu(t) Kaan F; Mongu Kan, Mongu Mongihu Kanis, Mungu Chan L; Magnus Kaam, Ma(n)guth (Kaam) P; Magon, Magu Chan, Mangu, Mengon, Mul Chan V; Mangu Cha(a)n, Mongu Cha(a)n VA; Magu Chan, Malgu, Malgu Gran Chan, Mangu Chan, Mongut Chan VB*” гэж тэмдэглэжээ.

Мөн христийн болон исламын шашинтнаас бусдыг “Idolatri” буюу онгон тахин шүтэгч, онгон шүтээнтэн гэх үгээр бичиж тэмдэглэсэн байна. Бусад олон бичмэлд “*idres, idules, ydoles, ydres, ydules F; adorans ydola, colens ydola, ydolatra L; adorare ydola, ydola colere, ydola venerare, ydolatra, ydolatria, ydolatria sectari, ydolatrie sectatores P; adorare idol(l)e, adorare l(e) idol(l)e, idolatri V; adorare le idol(l)e/i idoli. idol(l)atra / idolatri, idolatria VA; adorare idolli, g(i)ente idolatria, idolatra / idol(l)atri(i) VB; ydol(l)a adorantes ydol(l)a adorare, ydol(l)a col(l)ere, idolatri / ydolatri, ydolatria Z*” гэж дурджээ.

Марко Поло худалдаачин байсан тул төрөл бүрийн ургамал, халуун ногоо, амтлагч; алт, мөнгө, төмөр, зэс, ган, болд; биндэрьяа, маргад, бадмаараг, оюу номин зэрэг төрөл бүрийн үнэт чулуу; торго, бөс, шаазан, арьс нэхий эдлэл зэрэг гар урлалын зүйлсийг түлхүү тэмдэглэсэн байна.

Сарлагийг “... сэрвээн дээрээ хоёр төө өндөр том бөхтэй нэгэн үхэр ...”, нүүрсийг “... дүрэлзэж шатдаггүй бөгөөд маш их илчтэй түлдэг хар чулуу...” гэх мэтчилэн тэмдэглэсэн сонирхолтой мэдээлэл байгааг цаашид нарийвчлан судлах нь угсаатан зүйн талаас ач холбогдолтой судлагдахуун болно гэж үзэж байна.

Марко Пологийн аяллын номд очсон газар оронд нь элбэг тохиолдох боловч огт дурдаагүй, бусдад шүүмжлүүлсэн, ялангуяа хятадын соёлын холбогдолтой зарим нэг зүйл байна. Жишээлбэл, түүний номд цайны тухай ямар ч мэдээлэл дурдаагүй байна. Дундад зууны үеийн венецчүүд архи дарсанд их дуртай байсан тул Марко Пологийн худалдаачны сэтгэлгээнд цай гэдэг нь зарж худалдан ашиг олохоор бараа биш байв. Европт хүртэл өтгөн шар айраг, зөгийн бал болон халуун ногоотой хольж хийсэн халуун дарс өргөн хэрэглэдэг байсан учир цай сонирхох хүн бараг байгаагүй. Марко Полог худалдаачин байсан гэдгийг үргэлж санах хэрэгтэй. Үүгээрээ Марко Пологоос өмнө Дорно дахинд хүрсэн бусад аялагчдын тэмдэглэлээс онцлог юм. Тэрээр үзэж харсан, сонссон дуулснаа тэр хэвээр нь буюу харсан зүйлээ харсан, бусдаас сонссон зүйлээ сонссон гэж тодорхой бичсэн байна.

### Дүгнэлт

- Гар бичмэлийн олон хувилбарыг нэгтгэсэн нь монголчуудын төдийгүй тухайн үеийн ард түмний зан заншлыг дэлгэрүүлэн судлахад чухал хэрэглэгдэхүүн болох талтай.
- Бусад аялагчдын бүтээл дэх монголчуудын талаарх мэдээлэлтэй харьцуулан баримт мэдээг бататгахад дөхөмтэй.
- Уг чиглэлийн судалгааны ажлыг цаашид гүнзгийрүүлэхэд үндсэн суурь болох эрдэм шинжилгээний чухал ач холбогдолтой.
- Итали дахь монгол судлалын ажлыг идэвхжүүлэн, энэ чиглэлийн судалгааг хөгжүүлэхэд практик ач холбогдолтой.

## Ном зүй

### “Марко Пологийн аялал” номын хувилбаруудын хэвлэл

1. F = Eusebi, Mario (ed.) (2018). Marco Polo: Le Devisement dou monde. Testo secondo la lezione del codice fr. 1116 della Bibliothèque Nationale de France. Venezia: Edizioni Ca' Foscari. DOI <http://doi.org/10.30687/978-886969-223-9>. Filologie medievali e moderne 16. Serie occidentale 13.
2. Fr = Ménard Philippe (éd.) (2001-09). Marco Polo: Le devisement du monde. 6 voll. Genève: Droz.
3. K = Reginato, I. (ред.) (хэвлэвтэд байгаа). *La Version K (catalane) du Devisement dou monde: étude et éditions, Classiques Garnier, collection « Textes littéraires du Moyen Âge », série « Textescatalans du Moyen Âge »*.
4. L = Burgio, Eugenio (ред.) (хэвлэлийн эхийг бэлтгэж байгаа). Liber qui vulgari hominum dicitur Elmeliote o Liber domini Marchi Paulo de Venetiis. Epitome latina L. Venezia: Edizioni Ca' Foscari.
5. LT = Santoliquido, Vito (2018-19). Il «Liber descriptionis» di Marco Polo nel ms. parigino BnF, lat. 3195: edizione critica e studio [PhD thesis]. Venezia; Zurigo: Università Ca' Foscari: Universität Zürich.
6. P = Francesco Pipino O.F.P., Liber domini Marchi Pauli de Veneciis de condicionibus et consuetudinibus orientalium regionum (ed. interpr. di Samuela Simion sul cod. Firenze, Bibl. Riccardiana 983). URL [http://virgo.unive. it/ecf-workflow/books/Ramusio/testi\\_completi/P\\_marcatomain.html](http://virgo.unive. it/ecf-workflow/books/Ramusio/testi_completi/P_marcatomain.html)
7. R = Giovanni Battista Ramusio. De I viaggi di Marco Polo, gentil'huomo venetiano. Id. Secondo volume Delle Navigazioni et viaggi [...], in Venetia nella stamperia de' Giunti, L'anno MDLIX, ff. 2r-60r (ed. di Samuela Simion dalla copia Padova, Biblioteca Capitolare, 500.C5.4). URL [http://virgo.unive. it/ecf-workflow/books/Ramusio/testi\\_completi/R\\_marcatomain.html](http://virgo.unive. it/ecf-workflow/books/Ramusio/testi_completi/R_marcatomain.html)
8. TA = Bertolucci Pizzorusso, Valeria (ред.) (1975). Marco Polo: Milione. Versione toscana del Trecento. Milano: Adelphi.
9. TB = Amatucci, Eleonora (1982-83). La redazione toscana B del 'Milione' di Marco Polo: edizione critica [MA thesis]. Firenze: Università degli Studi di Firenze.
10. VA = Barbieri, Alvaro; Andreose, Alvise (ред.) (1999). Marco Polo: Il «Milione» veneto. Ms. CM 211 della Biblioteca civica di Padova. Venezia: Marsilio.
11. VB = Gennari, Pamela (2009-10). «Milione», redazione VB. Edizione critica commentata [PhD thesis]. Venezia: Univ. Ca' Foscari. URL [http://dspace.unive.it/bitstream/handle/10579/937/Gennari\\_955311.pdf?sequence=1\(2019-11-09\)](http://dspace.unive.it/bitstream/handle/10579/937/Gennari_955311.pdf?sequence=1(2019-11-09)).
12. Z<sup>o</sup> = Barbieri, Alvaro (ред.) (1998). Marco Polo: «Milione». Redazione latina del manoscritto Z. Parma: Fondazione Pietro Bembo/Guanda.

### Марко Пологийн тухай сүүлийн үеийн сонгосон хэвлэл (2000-2019)

1. Andreose, Alvise (2015). “Marco Polo’s *Devisement dou monde* and Franco-Italian tradition”. *Francigena*, I: 217-42.
2. Andreose, Alvise; Concina, Chiara (2016). “A monte di F e f. Il *Devisement dou monde* e la scripta dei manoscritti francesi di origine pisano-genovese”. In Pioletti, Antonio; Rapisarda, Stefano (eds.), *Forme letterarie del Medioevo romanzo: testo,*

- interpretazione e storia*. Atti dell'XI Congresso della SIFR (Catania, 22-26 settembre 2015). Soveria Mannelli: Rubbettino:15-37.
3. Andreose, Alvise (2016). «...io essendo giovanetto n'ho udito molte fiato dire...». Alcune riflessioni sulle fonti dei *Viaggi di messer Marco Polo* di Giovanni Battista Ramusio. *Quaderni Veneti*, n.s., 6, 2: 1-14.
  4. Andreose, Alvise (2017). “Marco Polo e la grant *peitere* per il vino del Gran Can”. In Iannello, Tiziana (ed.), *Est-Asia. L'interscambio culturale scientifico ed economico*. Atti del Convegno internazionale (Novedrate, June 18-19, 2015). Roma: Aracne: 77-90.
  5. Andreose, Alvise (2018). “Il greco di Marco Polo”. In Andreose, Alvise; Borriero, Giovanni; Zanon, Tobia (eds.), “*La somma de le cose*”. *Studi in onore di Gianfelice Peron*. Padova: Esedra: 127-36.
  6. Barbieri, Alvaro (2004). *Dal viaggio al libro. Studi sul 'Milione'*. Verona: Fiorini.
  7. Bat-Uchral, G.; Ragagnin, Elisabetta; Simion, Samuela (eds.) (2019). *Marko Pologiyn ayalal. 1559 oni Ramuziogiyn huvilbar*. Ulaanbaatar: Soyombo.
  8. Battaglia Ricci, Lucia (ed.) (2001). *Marco Polo: Milione*. Firenze: Sansoni.
  9. Bertolucci Pizzorusso, Valeria (2011). *Scritture di viaggio. Relazioni di viaggiatori ed altre testimonianze letterarie e documentarie*. Roma: Aracne.
  10. Bianchi, Vito (2007). *Marco Polo: storia del mercante che capì la Cina*, Bari, Roma, Laterza.
  11. Burgio, Eugenio (2018). *Marco Polo, 'Le Devisement dou monde', II. Glossario, a cura di Eugenio BURGIO, Venezia, Edizioni Ca' Foscari Digital Publishing, Venezia: Edizioni Ca' Foscari - Digital Publishing, vol. 1.*
  12. Burgio, Eugenio; Simion, Samuela Simion (2018). “*La ricezione medievale del Devisement dou monde (secoli XIV-XV)*”, *Medioevo Romano*, XLII: 173-194.
  13. Burgio E., Simion S. (ed.). 2015. Giovanni Battista Ramusio: Dei viaggi di Messer Marco Polo veneziano (“*Navigazioni et viaggi*”, II, 1559): Edizione critica digitale progettata e coordinata da Eugenio Burgio, Marina Buzzoni, Antonella Ghersetti. Venezia: Edizioni Ca' Foscari, 2015. (Filologie Medievali e Moderne 5 / Serie Occidentale 4.) ([http://virgo.unive.it/ecf-workflow/books/Ramusio/testi\\_completi/P\\_marcato-main.html](http://virgo.unive.it/ecf-workflow/books/Ramusio/testi_completi/P_marcato-main.html))
  14. Busi, Giulio (2019). *Marco Polo: viaggio ai confini del Medioevo*. Milano: Mondadori.
  15. Capusso, Maria Grazia (2008). “La mescidanza linguistica del *Milione* franco-italiano”. In Conte (2008), 263-85.
  16. Cattaneo, Angelo (2011). *Fra Mauro's Mappa Mundi' and Fifteenth-Century Venice*. Turnhout: Brepols.
  17. Cigni, Fabrizio (2017). “Rustichello da Pisa”, *Dizionario biografico degli Italiani*, 89 [online: [http://www.treccani.it/enciclopedia/rustichello-da-pisa\\_%28Dizionario-Biografico%29/](http://www.treccani.it/enciclopedia/rustichello-da-pisa_%28Dizionario-Biografico%29/)]
  18. Concina, Chiara (2007). “Prime indagini su un nuovo frammento francoveneto del *Milione* di Marco Polo”. *Romania*, 125, 342-69.
  19. Conte, Silvia (ed.) (2008). *I viaggi del Milione: Itinerari testuali, vettori di trasmissione e metamorfosi del Devisement du monde di Marco Polo e Rustichello da Pisa nella pluralità delle attestazioni = Atti del Convegno internazionale (Venezia, 6-8 ottobre 2005)*. Roma: Tiellemedia.
  20. Falchetta, Piero (2006). *Fra Mauro's World Map*. With a commentary and translations of the inscriptions; presentation by Marino Zorzi. Turnhout: Brepols.



21. Gadrat-Ouerfelli, Christine (2015). *Lire Marco Polo au Moyen Age. Traduction, diffusion et réception du Devisement du monde*. Turnhout: Brepols.
22. Gaunt, Simon (2013). *Marco Polo's 'Le Devisement du Monde': Narrative Voice, Language and Diversity*. Cambridge: Brewer.
23. Gennari, Pamela (2010). «Sui rapporti tra i codici della redazione VB del *Milione*». *Quaderni Veneti*, 49-50, 39-66.
24. Grisafi, Attilio (2008). «Il *Milione* nella cultura occidentale: fruizione e funzione della traduzione di Pipino da Bologna», *Schede medievali*, 46, 179-88.
25. Grisafi, Attilio (2014). «Il *Milione* di Marco Polo: aspetti testuali e linguistici della traduzione latina di Francesco Pipino da Bologna», *Itineraria*, 13, 45-69.
26. Jacoby, David (2018). *Medieval trade in the Eastern mediterranean and beyond*. London; New York: Routledge.
27. Kinoshita, Sharon (2016) Marco Polo, *The Description of the World*, translated, with an introduction and annotations, by Sharon Kinoshita; maps and genealogies by Ian Mladjov, Indianapolis et Cambridge, Hackett, 2016
28. Mascherpa, Giuseppe (2018). «Una Venezia d'Oriente. Gli splendori di Quinsai nella tradizione del *Devisement dou monde*». Mascherpa; Strinna (2018), 63-88.
29. Mascherpa, Giuseppe; Strinna, Giovanni (eds.) (2018). *Predicatori, mercanti, pellegrini. L'Occidente medievale e lo sguardo letterario sull'Altro tra l'Europa e il Levante*. Mantova: Universitas Studiorum
30. Masini, Federico; Franco, Salvatori; Schipani, Sandro (eds.) (2006). *Marco Polo 750 anni. Il viaggio, il libro, il diritto*. Roma: Tiellemedia.
31. Ménard, Philippe (2019). “Guerres entre Mongols. L'empereur Khoubilai Khan contre le prince Nayan dans le texte de Marco Polo. Essai de critique textuelle”. In Douchet, Sébastien et al. (eds.), *De la pensée de l'histoire au jeu littéraire. Études médiévales en l'honneur de Dominique Boutet*. Paris: Champion: 201-210.
32. Montesano, Marina (2014). *Marco Polo*. Roma: Salerno.
33. Pozza, Marco (2006). “Marco Polo Milion. An unknown source concerning Marco Polo”, *Medieval Studies*, 68. 285-302.
34. Racine, Pierre (2011). “Marco Polo, marchand ou reporter?”, *Le Moyen Age*, 117, 315-344 [online <http://www.cairn.info/publications-de-Racine-Pierre--1077.htm>]
35. Racine, Pierre (2012). *Marco Polo et ses voyages*, Paris: Perrin.
36. Ragagnin, Elisabetta (2017). L'ambiguità del teonimo poliano *Natigay – Načigay*. In: Crifò, F. & Rinaldin, A. (eds.), *Quaderni Veneti* 6/2(2017). Venezia: Edizioni Ca' Foscari. 103-112.
37. Ragagnin, Elisabetta (in print) Some further notes on Marco Polo's Tatar Gods. To appear in: *Acta Mongolica*.
38. Ragagnin, Elisabetta; Khabtagaeva, Bayarma (2018). Nekotorye zametki ob «arc(h)olino» / «cocolino» v zapisjax Marko Polo [Some notes on the term «arc(h)olino» / «cocolino» in the travelogue of Marco Polo]. *Sibirskij Filologičeskij Žurnal/Siberian Journal of Philology* 2018/4, 129-136.
39. Ragagnin, Elisabetta; Simion, Samuela (in print). A new tool for Mongolic studies: the critical digital edition of Giovanni Battista Ramusio's *Viaggi di messer Marco Polo (1559)*. In: Rykin, P. et al. (eds.), *Mongolic Languages and Written Culture of Mongolian Peoples: Proceedings of the Second International Conference on Mongolic Linguistics (Elista, May 18–21, 2016)*.
40. Reginato, Irene (2018). «La variazione lessicale nel *Milione*. Interferenza linguistica e costanti interpretative». *Quaderni Veneti*, 6 (2), 77-102.

41. Reichert, Folker (2013). “Marco Polo und die chinesische Stadt”. In *Vieler Völker Städte. Polyethnizität und Migration in Städten des Mittelalters*: 137-158. [online: <https://stadtarchiv.heilbronn.de/fileadmin/daten/stadtarchiv/online-publikationen/12-vieler-voelker-staedte.pdf>]
42. Sangorrín Guallar, Francesco (ed.) (2016). *El libro de Marco Polo: version aragonesa del siglo 14*. Zaragoza: Institucion Fernando El Catolico.
43. Santoliquido, Vito (2018-19). *Il «Liber descriptionis» di Marco Polo nel ms. parigino BnF, lat. 3195: edizione critica e studio* [PhD thesis]. Venezia; Zurigo: Università Ca’ Foscari; Universität Zürich.
44. Simion, Samuela (ed.) (2016). *Benedetto, Luigi Foscolo: Livre de messire Marco Polo citoyen de Venise, appelé Milion, où sont décrites les Merveilles du monde*. Traduzione critica secondo le carte inedite del lascito di Ernest Giddey. Venezia: Edizioni Ca’ Foscari.
45. Samuela Simion (2019). *Marco Polo, Il Devisement dou monde nella redazione veneziana V (cod. Hamilton 424 della Staatsbibliothek di Berlino). Tomo 1*, Venezia: Edizioni Ca’ Foscari. [https://edizionicafoscari.unive.it/en/edizioni4/libri/978-88-6969-322-9/]
46. Tanase, Thomas (2016). *Marco Polo*. Paris: Ellipses.
47. Tanase, Thomas (2019). “In the heart of Asia: Marco Polo, from Venice to Tibet”. In *Menache, Sophia; Kedar, Benjamin Z.: Balard, Michel (eds.), Crusading and Trading between East and West. Studies in Honour of David Jacoby*. London: Routledge: 216-27.
48. Veneri, Toni (2012). “Il riscatto geografico di Marco Polo”, *Quaderni Veneti*, 1(2), 33-57.
49. Vogel, Hans U. (2013). *Marco Polo «Was» in China: New Evidence from Currencies, Salts and Revenues*. Leiden: Brill.